

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны 10 дугаар тэмдэглэлд:

“ХИҮ.7. Засгийн газрын 2012 оны 131 дүгээр тогтоолын дагуу Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан 2013 онд хэрэгжүүлэх улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын явцын талаар Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

7.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад тусгагдсан 2013 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт 2013 оны 3 дугаар сарын 11-ний дотор Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Үйлдвэр, хөдөө аж, ахуйн сайд Х.Баттулга болон бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.

7.2. Техникийн тодорхойлолт, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгаврыг боловсруулан батлах боломжгүй болон батлагдсан төсөв нь хүрэлцээгүй төсөл, арга хэмжээг ангилан гаргаж, төсвийн тодотголд санхүүжилтийг нэмж тусгах эсхүл уг төсөл арга хэмжээг бүхэлд нь хасах талаар төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн саналыг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагвад даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР